

“ӨСВӨР НАСНЫ ХҮНД ОНОГДУУЛСАН ХОРИХ ЯЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ОНЦЛОГ”

"THE CURRENT SITUATION, CHALLENGES, AND CHARACTERISTICS OF JUVENILE INCARCERATION: A COMPARATIVE ANALYSIS WITH SELECTED FOREIGN COUNTRIES"



З.Түвшинжаргал

Дотоод хэргийн их сургууль, Сургалт, судалгааны 403 дугаар анги-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн Аюулгүй байдлын тэнхимийн ахлах багш, хууль зүйн магистр, хошууч tuvshin1108@gmail.com



Г.Сайханзаяа

ШШГЕГ-ын харьяа Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын багш, дэслэгч anukzaya0119@gmail.com

Товч утга: Дэлхийн улс орнуудын эрүүгийн эрх зүйн ялын бодлогод “гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага болон хорих ялыг оногдуулах, хэрэгжилтийг хангуулах, ямар орчин нөхцөлд ялыг эдлүүлэх, тэднийг хэрхэн нийгэмшүүлэх” нь ихээхэн анхаарал татсан асуудал болоод байна.

Шинэчлэн батлагдсан Эрүүгийн болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн баримт бичигт “сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын нөхцөл, журам, чөлөөний асуудлыг нарийвчлан зохицуулаагүй орхигдуулсан нь” практик хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөх нөхцөлийг бүрдүүлж байна. (хууль, 2017)

Иймд өсвөр насны хүнд оногдуулсан хорих ял эдлүүлэх ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг “судалгааны үндсэн дээр нээн илрүүлэх, өсвөр насны хоригдлын чөлөөний асуудлыг тодорхойлох” хэрэгцээ шаардлага байна гэж судлаачийн хувьд үзэж байна.

Abstract: In the criminal justice policies of countries around the world, "imposing criminal liability and imprisonment on juvenile offenders, ensuring their

implementation, the environment in which they serve their sentences, and how to socialize them" have become a major concern.

The newly adopted Criminal and Court Enforcement Laws and other legal documents issued in accordance with them “fail to provide detailed regulation of the conditions, procedures, and leave issues of special educational institutions,” creating conditions that will negatively affect practical implementation. (Law, 2017)

Therefore, the researcher believes that there is a need to "research and identify issues related to the execution of juvenile prison sentences and to determine the issue of juvenile prison release."

Түлхүүр үгс: Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага, өсвөр насны хүн, ял шийтгэл, эрүүгийн эрх зүй, ялын бодлого.

Keywords: Special educational institutions, adolescents, punishment, criminal law, sentencing policy.

УДИРТГАЛ

Монгол улсын хувьд өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага шүүхээс ял оногдуулж, хэрэгжилтийг хангуулж ирсэн ч эрдэмтэн, судлаачдын бүтээл болон түүхийн эх сурвалжид “*Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын үйл ажиллагаа, эрх зүйн зохицуулалтын талаар нарийвчлан тусгасан, цаашидын чиг хандлагыг эрэлхийлсэн*” тусгайлсан судалгаа, шинжилгээний бүтээл алга байна. (Э.Жамбалрагчаа, 2021)

Өсвөр насны хоригдлын эрх зүйн статус, тэдний чөлөөний асуудал нь олон улсын болон дотоодын хууль, стандартын хүрээнд тодорхойлогддог. Энэ илтгэлд өсвөр насны хоригдлын эрх, тэдний чөлөөний асуудлыг зохицуулж буй эрх зүйн үндэслэлүүдийг авч үзлээ. Нийгэм, эдийн засаг, улс төрийн хүрээнд явагдаж буй өөрчлөлт, шинэчлэлийн явцад ажилгүйдэл, ядуурал, түүнээс улбаатай архидалт, биеэ үнэлэх, мансуурал зэрэг нийгмийн сөрөг үзэгдлүүд (С.А., 2019), эцэг, эх асран хамгаалагчаас үр хүүхдэдээ тавих хяналт суларснаас хүүхэд сургууль завсардах, гэр орноосоо дайжих, элдэв сөрөг нөлөөнд автах, улмаар гэмт хэрэг үйлдэх, гэмт халдлагад өртөх явдал сүүлийн жилүүдэд төдийлөн буурахгүй, ноцтой гэмт хэргүүд үйлдэгдэж олныг түгшээж байна.

Манай улсын хувьд насанд хүрээгүй хүний үйлдэж байгаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил төр засгийн анхаарлын төвд байж олон талт арга хэмжээ хэрэгжүүлж байгаа ч тэдний үйлдэж байгаа гэмт хэрэг жил ирэх тусам ихсэж, (Д.Дамдинцэрэн, 2021) хорих ял шийтгүүлсэн өсвөр насны хоригдлын тоо нэмэгдсээр байгаа бөгөөд манай улсын хувьд сүүлийн 5 жилийн байдлаар нийт 48656 хүн шүүхээр ял шийтгүүлснээс өсвөр насны хүнд ял шийтгүүлсэн тоо 1869 буюу 3.5 %- ийг эзэлж байна. (Б.Тамир, 2021) Иймд гэмт хэрэгт холбогдсон өсвөр насны хүүхдүүдийн хэрэгт холбогдсон шалтгаан, ар гэрийн байдал, гэмт хэрэг

үйлдсэн нас, гэмт хэрэг үйлдсэн төрөл, Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлсэн байдлын давтамж, Хорих ял шийтгүүлсэн өсвөр насны хоригдлуудын гэмт хэрэгт холбогдоход нөлөөлсөн шалтгаан нөхцөл, Өсвөр насны хоригдлуудын хорих ангид хуваарилагдаж ирэх үеийн өөрийн үнэлгээний байдал, хоригдлын чөлөөний асуудлыг хууль, журамд хэрхэн тусгасан, гадаадын улс орнуудад хэрхэн зохицуулдаг болохыг судлах юм.

ҮНДСЭН ХЭСЭГ

Монгол Улсын өнөөгийн нийгэмд өсвөр насныхан яагаад гэмт хэрэгт холбогддог вэ? Тэднийг ийм үйлдэл хийхэд хүргэдэг гол шалтгаан юу байна вэ? Энэхүү илтгэлээр өсвөр насны хоригдлуудын гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлж буй нөхцөл байдал, нийгмийн орчин, тэдний эрх зэрэг асуудлыг хөндөж, уг асуудлын үндэс суурийг олж тогтоохоор зорилоо.

“Өсвөр насны хүн” гэдэгт насны тодорхой үе, тухайлбал 10-18 насны хүмүүсийг хэлнэ. Энэ үе нь хүн төрөлхтний амьдралд хөгжлийн чухал үе шатыг илтгэдэг бөгөөд бие, сэтгэл зүй, нийгмийн хувьд олон өөрчлөлтүүд гарах үе юм. (газар, 2021)

Олон улсад: “Өсвөр насны хүн”-ийг Нэгдсэн үндэсний байгууллагын хүүхдийн эрхийн тухай конвенц /1989/ өсвөр насны хүмүүсийг 10-19 насныхан гэж тодорхойлжээ.


Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд /2017/ “Өсвөр насны хүнд ял эдлүүлэх” талаар заасан байдаг. Хууль тогтоомжийн хүрээнд өсвөр насны хоригдлуудын эрх, хамгаалалт, хүмүүжүүлэх асуудлыг зохицуулахад чухал ач холбогдолтой.

Эрүүгийн эрх зүйд 18 насанд хүрээгүй боловч 16 насанд хүрсэн хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх бөгөөд эрүүгийн хуульд тусгайлан заасан зарим төрлийн гэмт хэрэгт 14 насанд хүрсэн хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Иймд 14 насанд хүрсэн, 18 насанд хүрээгүй этгээдийг ойлгоно. (С.Нарангэрэл, 2006)

Хорих ял эдэлж байгаа өсвөр насны хүнд ерөнхий боловсролын болон мэргэжил эзэмшүүлэх сургалтад хамруулах суллагдаж гараад ажилд ороход зориулж бэлтгэдэг. 1955 онд НҮБ-аас батлан гаргасан “Хэрэгтэн ялантай харьцах наад захын жишиг дүрэмд “Хоригдогчид ашиг тустай , тэр өөрөө авьяас сонирхолтой нөхцөлд тухайн улс оронд зөвшөөрөгдсөн шашны хүмүүжлийг хүртэл багтаасан боловсрол олгох сургалтыг цаашид үргэлжлүүлэх боломжоор хангана. Бичиг үсэггүй буюу залуу хоригдогчдыг сургалтад заавал хамруулах ба үүнд хорих газар онцгой анхаарал тавих ёстой. Хоригдогчийг тухайн орны боловсролын системийн дагуу сургана. Энэ нь хорих газраас суллагдсан хоригдогч цаашид суралцахад хүндрэл учруулахгүй байхад оршино” гэж заасан байдаг. (А.Лхагва, 2024)


Судлаачийн зүгээс Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад сүүлийн 5 жилд хорих ял эдэлсэн өсвөр насны хоригдлыг статистик мэдээнд дүн шинжилгээ хийх арга ашиглан судалгаа хийлээ.

Нэг. Насанд хүрээгүй хоригдлын гэр бүлийн байдал




Гэмт хэрэг үйлдсэн нийт хүүхдүүдийн 47.4 % нь гэр бүл салсан, хойд эх эсвэл хойд эцгийн хамт амьдардаг, 13.8% асрамжийн газарт нийт хүүхдүүдийн ихэнх буюу 61.2% нь бүрэн бүтэн гэр бүлд биш зөрчил маргаан ихтэй, халамж анхаарал дутмаг гэр бүлд амьдарч байгаа нь харагдаж байна.

Хоёр. Өсвөр насны хүний гэмт хэрэг үйлдэх үеийн насны байдлыг харуулбал:




Гэмт хэрэгт холбогдсон өсвөр насны нийт 35 хоригдлын 71.3 % буюу дийлэнх нь 15-17 настайдаа 28.7% нь 18-20 настайдаа тус тус гэмт хэрэг үйлдэж, хорих ял шийтгүүлсэн байна.

Гурав. Үйлдсэн гэмт хэргийн төрлөөр нь авч үзвэл:




Хорих ял шийтгүүлсэн өсвөр насны хоригдлуудын хувьд эрүүгийн хуульд заасан “...хулгайлах, дээрэмдэх, хүний амь нас эрүүл мэндэд хохирол учруулах, мансууруулах эм сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэх, хүчиндэх...” гэмт хэргүүдийг үйлдсэн байх бөгөөд үүнээс “...бусдын бэлгийн эрх чөлөөнд халдсан...” буюу “хүчиндэх” гэмт хэрэг 61.1%-ийг эзэлж байна.

Дөрөв. Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлсэн байдлын давтамж:



Шүүхээс гэм буруутайд тооцож, хорих ял шийтгүүлсэн өсвөр насны хоригдлын 83.3% нь анх удаа үйлдсэн, 11.1% хувь нь 2 ба түүнээс олон удаа, 4.7% нь 3 болон түүнээс дээш удаа гэмт хэрэг үйлдсэн байна.

Тав: Хорих ял шийтгүүлсэн өсвөр насны хоригдлуудын гэмт хэрэгт холбогдох нөлөөлсөн шалтгаан нөхцөл:



Эндээс үзэхэд “...ар гэрийн хараа хяналтгүй сул, санхүүгийн чадамжгүй байдал, гэр бүлийн зөрчил маргаан ихтэй, согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ өөрийгөө хянах чадваргүй болсон...” зэрэг нөхцөл байдлууд нь өсвөр насны хоригдлуудын гэмт хэрэгт холбогдоход хамгийн их нөлөөлсөн хүчин зүйлс болж байна.

Тэгвэл гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн **“Өсвөр насны хоригдлын ял эдлэх хугацаанд ар гэрт гачигдал гарсан тохиолдолд чөлөө олгох асуудлыг хуульд нарийвчлан авч үзэх шаардлагатай байна.** Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар “Хоригдолд чөлөө олгох” асуудлыг шийдвэрлэхээр заасан хэдий ч насанд хүрээгүй хоригдлын талаар тусгайлан зохицуулсан зохицуулалтгүй байна. Гэвч насанд хүрээгүй хоригдлуудын хувьд төрөл, садны хүн хүндээр өвчилсөн, эсхүл нас барсан, гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсоны улмаас ар гэрт нь үлэмж хор хөнөөл учирсан бол тухайн хоригдлын зан байдал, засрал хүмүүжлийг харгалзан хорих ангийн дарга зам хоногийг оролцуулан 7 хүртэл хоногийн чөлөө олгоно (Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, 2017) гэж ерөнхий зохицуулалтын хүрээнд зохицуулагдаж байна.

Хүүхдийн эрхийн тухай хууль /2016/, “Хүүхэд хамгааллын тухай хууль” /2024/, “Гэр бүлийн тухай хууль” /1999/, “Эрүүгийн хууль” /2015/, зэрэгт хүүхдийн эрхийн талаар нарийвчлан заасан байгааг харахад өсвөр насны хоригдлуудын эрх зөрчигдөж байна гэх үндэслэл байна.

Өсвөр насны хоригдлуудын эрхийг хамгаалах нь чухал бөгөөд тэдэнд:


- Боловсрол эзэмших эрх
- Сэтгэл зүй, эрүүл мэндийн үйлчилгээ авах эрх
- Хууль зүйн зөвлөгөө авах эрх
- Нийгэмд бүрэн дүүрэн оролцох эрх зэргийг баталгаажуулах хэрэгтэй.

Чөлөө олгохгүй байгаа шалтгааныг дараах байдлаар харж байна.

Үүнд:

- Хоригдсон өсвөр насны хүүхдүүдийн сэтгэл зүйн байдал тогтворгүй байдаг.
- Асран хамгаалагч, харгалзан дэмжигч, итгэмжлэгдсэн хүн байдаггүй.
- Оргох магадлал өндөр байдаг тул удаан хугацаагаар чөлөө олгох боломжгүй.
- Хүүхдүүдийн харилцаа холбоо алдагддаг. Тэдний ирээдүйд сөрөг нөлөөтэй байх эрсдэлтэй.
- Хоригдлын чөлөөт байдал нь тэдний сэтгэл зүй, боловсрол, нийгэмд оролцох чадварт нөлөөлдөг.
- Амь бие, эрхтэндээ гэмтэл учруулж болзошгүй гэж үзсэн.

Өсвөр насны хоригдлуудаас дараах асуулгаар санал авахад чөлөө авч явах шаардлагатай гэж санал өгсөн 70%, ээжийн бие өвдсөн учраас чөлөө авах шаардлагатай гэж үзсэн 50%, аавын бие өвдсөн шалтгаанаар 30%, эмээ, өвөө нас барсан шалтгаанаар 10% гэсэн санал асуулгын дүн гарсан байна. Сүүлийн 3 жилд чөлөө авахаар Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хүсэлт гаргасан насанд хүрээгүй нийт 12 хоригдол байна. Гэвч дээрх шалтгаанаас үүдэлтэй насанд хүрээгүй нэг ч хоригдол чөлөө авч чадаагүй байна.



Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад ажиллаж байгаа албан хаагчдын 15 нь буюу 50 хувь нь эрх зүйч, 2 нь буюу 6 хувь нь багш мэргэжилтэй байна. (Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын тайлан, 2020-2025)

Гадаадын зарим орны өсвөр насны хүнийхорих ял эдлүүлэх ажиллагааны онцлог:

Оросын Холбооны Улс: 1996 онд ОХУ-ын Эрүүгийн ял эдлүүлэх хууль батлагдан мөрдөгдөж эхэлсэн байна. ОХУ-ын Эрүүгийн ял эдлүүлэх хуульд зааснаар засан хүмүүжүүлэх колонид ял эдлэгсдийн орон байрны талбайг ялгавартайгаар тогтоож хуульчилсан. Тухайлбал: Засан хүмүүжүүлэх колонид 2,

гянданд 2.5, эмэгтэйчүүдийн колонид 3, хүүхдийн колонид 3.5 талбай нэг хоригдолд оногдуулахаар тогтоожээ. (Н.Гантулга, 2015)

ОХУ-ын хуулиар насанд хүрээгүй хүүхэд гэдэгт 14-18 насны хүнийг хэлнэ. Тус улсын Эрүүгийн хуулиар, дараах гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд, насанд хүрээгүй буюу өсвөр насны хүүхдэд 14 наснаас эрүүгийн хариуцлага хүлээлгээр заажээ. Үүнд:

- Хүнийг алах (105);
- Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах (111);
- Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах (112);
- Хүн хулгайлах (126);
- Хүчиндэх (131);
- Бэлгийн шинжтэй хүчирхэлсэн үйлдэл (132);
- Хулгайлах (158);
- Дээрэмдэх (161);
- Хүндрүүлэх нөхцөлтэйгөөр бусдын эд хөрөнгийг устгах, гэмтээх (167 дугаар зүйлийн 2 дахь хэсэг),
- Террорист ажиллагаа явуулах (205);
- Хүн барьцаалах (206);
- Террорист ажиллагааны талаар санаатай худал мэдээлэх (207);
- Хүндрүүлэх нөхцөлтэйгөөр танхайрах (213);
- Түүх соёлын хөшөө, дурсгалт зүйлийг санаатайгаар устгах (214);
- Галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх зүйл болон бууны сум хулгайлах (статья 226);
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хулгайлах (229);
- Тээврийн хэрэгсэл, эсвэл төмөр замыг ажиллагаагүй болгох (267). зэрэг болно. Эдгээрээс бусад төрлийн хүнд гэмт хэрэгт 16 наснаас эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр хуульчилсан байна. Тус улсад, өнөөдөр охидын 2, хөвгүүдийн 60, нийт 62 хүмүүжлийн колони 54 байршилд үйл ажиллагаа явуулж байна. Сахилга бат сайтай байсан тохиолдолд, насанд хүрээгүй хоригдолд дараах урамшуулал олгоно. Үүнд:- хөнгөн дэглэмтэй хорих ангид шилжүүлэх;
- колонийн харгалзагчийн хамт спорт болон соёл, урлагийн арга хэмжээнд оролцох; -хугацаанаас өмнө суллагдах;
- тодорхой хугацаагаар эх, эцэг, төрөл садны харгалзаатай колонийн байршлаас гарах.

Сахилга батын зөрчил гаргасан тохиолдолд, дараах арга хэмжээг авна.Үүнд:

- сануулах;
- сахилгад хийх;
- сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр торгох;
- чөлөөт цагт хориг тавих юм.

2018 онд тус улсын Ял эдлүүлэх холбооны албаны явуулсан судалгаагаар, тус улсын засан хүмүүжүүлэх газарт нийт 1500 орчим насанд хүрээгүй хоригдол хорих ял эдэлж байна. Уг үзүүлэлтийг сүүлийн 15 жилтэй харьцуулахад, даруй 10 дахин буурчээ. Тухайлбал, 2002 оны 1 дүгээр сард, тус улсын хэмжээнд, нийт 18,6 хүүхэд ял эдэлж байжээ. Гэхдээ, өнөөдөр, тус улсын ялын бодлогын чиг хандлага өөрчлөгдөж, улмаар зөвхөн хүнд болон онц хүнд гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй хүүхдийг засан хүмүүжүүлэх газарт байрлуулахаар хуульчилсан байна.

Вьетнам улс: Вьетнамд насанд хүрээгүй этгээд болгоомжгүй болон санаатай боловч хүнд биш гэмт хэрэг үйлдсэн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэдэггүй. Тэдэнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын агуулга нь хүмүүжүүлэх, нийгэмд хэрэгтэй хүн болгохын тулд тэднийг зөв хөгжихөд нь туслалцаа үзүүлэх нь гол зорилгыг агуулдаг бөгөөд үүндээ чиглэсэн тусгай сургуулиудыг олноор байгуулжээ. Энэхүү засан хүмүүжүүлэх сургуульд 1-3 жил хүртэл байх бөгөөд хүмүүжил сайтай хүүхдүүдийг тогтоосон хугацаанаас өмнө сулладаг.

Англи улс: Английн эрүүгийн эрх зүйн субъект: Аливаа бие хүн Английн харьяат, гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг эрүүгийн хариуцлагад татаж болно. Өөрийн статусын дагуу зарим хүмүүс эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгддөг журамтай. Нэгдүгээрт: Уламжлал ёсоор хаан, хатан гэмт хэрэг үйлдэж болохгүй учир хариуцлагад татагдахгүй. Хоёрдугаарт: Дипломат эрх ямбийн тухай 1964 оны хуулийн дагуу элчин болон гадаадын элчин сайдын яамны албаны бусад хүмүүс эрүүгийн мөрдөлтөд халдашгүй байх эрх эдэлнэ.

Английн эрх зүйд насанд хүрээгүй байдлыг хүсэл зориг байхгүйтэй холбогддог бөгөөд энэ нь эрүүгийн хариуцлага үгүйсгэгдэх шалтгаан болж болно. Английн Эрүүгийн хууль тогтоомжид насанд хүрээгүй хүмүүсийг 3 бүлэгт хуваасан байдаг.

-10 хүртэлх насны хүүхдүүд

-10-14 насны хүүхдүүд

-14-17 насны өсвөр насныхан /ял оногдуулахад 17-21 насны хүмүүсийг тэдгээртэй адилтган үздэг/ (Б.Ганчулуун, 2005). Хүүхэд ба өсвөр насны хүмүүсийн тухай 1933 оны хууль гарахаас өмнө нийтийн эрх зүйн дагуу 7 нас

хүрээгүй хүүхдийг эрүүгийн хариуцлагад татаж болдоггүй байсан. Уг хуулиар эрүүгийн хариуцлага хүлээлгэх насыг 7, Хүүхэд ба өсвөр насны хүмүүсийн тухай 1969 оны хуулиар 10 байхаар тогтоосон.

10-14 насны хүүхдийн үйлдэлд гэмт хэргийн элементийн аль аль нь Actus reus ба mens rea байгааг ямар ч эргэлзээгүй нотлохоос гадна уг хүүхэд ноцтой хохирол учруулж байгаага мэдэж байсныг тогтоосон нөхцөлд л түүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэж болно.

Гэмт хэрэг үйлдсэн 14-17 насны этгээдэд шүүх гэр бүл, асран хамгаалагчийн хяналтад байлгах шийдвэр гаргах эрхтэй. Энэхүү шийдвэрт гэмт хэрэг үйлдсэн этгээд хянагчийн шаардлагыг биелүүлэх, тусгай тогтоосон хугацаанд тодорхой газар оршин суух, тодорхой өдөр хүмүүжлийн төвд ирэх, 6 цагаас өглөөний 6 цагийн хооронд гэрээс гадагш гарахгүй байх /шөнийн хязгаарлалт/ мөн тодорхой өдрүүдэд ямар нэг үйл ажиллагаанд оролцохыг хориглохыг заасан байдаг байна. Шүүх 12-15 насны хүмүүсийг хүмүүжлийн хаалттай төвд илгээх, төвд байлгах хугацаа нь 4, 6, 8, 10, 12, 18, 24 сар байна. Тэнд байх хугацаанд нь гэмт хэрэг, эрх зүйн зөрчил гаргасан этгээдэд хөдөлмөрийн дадлага, боловсрол олгох бөгөөд суллагдахад бэлтгэдэг.

Энэ бүхнээс үзэхэд Англи улсад 21-ээс доош насны гэмт хэрэг үйлдсэн хүүхэд, залуучууд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын зорилго нь аль болох нийгмээс тусгаарлахгүйгээр хүмүүжүүлэх, тусгаарласан ч хамгийн богино хугацаагаар хэрэглэдэг нь харагдаж байна. Мөн Английн эрүүгийн ялын тогтолцоонд насанд хүрээгүй хүмүүст зориулсан ял гэсэн тусгай ялын төрөл байгаа нь анхаарал ихээр татаж байсан болно. Англи улсын ял эдлүүлэх байгууллага нь төвийн ба орон нутгийн шоронгийн байгууллагаас бүрдэнэ. (Б.Ганчулуун, 2005) Орон нутгийн ял эдлүүлэх байгууллагад гол төлөв хэрэг нь шүүхэд шилжихийн өмнөх болон шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болохыг хүлээж байгаа хүмүүс хоригддог. Мөн

- Богино хугацаагаар хорих ял эдлэгсэд
- Торгууль төлөөгүй буюу бага хохиролтой гэмт хэрэг үйлдэгсэд
- 21 хүртэлх насны хүүхэд залуучууд хоригддог байна. Эдгээр төрлүүдэд ял эдлэгсдийн үйлдсэн гэмт хэргийн байдал засрал хүмүүжлийн түвшнийг судлан тогтоож, улмаар тэднийг ял эдлүүлэх байгууллагын өөр төрөлд шилжүүлэх журам.

Казахстан улс: Казахстан улсын Эрүүгийн ял эдлүүлэх хуульд Хорих ял шийтгэгдсэн насанд хүрээгүй этгээдийн харьцаанд тогтоосон журам нь ерөнхийдөө ОХУ-ын Эрүүгийн ял эдлүүлэх хуулийн холбогдох зохицуулалттай адил (Эрүүгийн ял эдлүүлэх хууль) боловч дараах онцлогийг тодотгож болно.

- а. Насанд хүрээгүй хүмүүсийн хорих ялыг эдлэх байгууллагыг “Насанд насанд хүрээгүйчүүдийг хорих аюулгүй байдлын түвшний байгууллага”

гэж нэрлэдэг ба тэрээр бие даасан хорих байгууллагын төрөл мөн. (улс, Эрүүгийн ял эдлүүлэх хууль)

б. Хэрэв ОХУ-ын Эрүүгийн ял эдлүүлэх хуулийн дагуу энэ улсад хорих ял эдэлж буй насанд хүрээгүй хүнд тоон хязгаарлалтгүйгээр илгээмж, гуйвуулга авахыг зөвшөөрдөг бол Казахстан улсын хувьд ердийн нөхцөлд ял эдэлж буй насанд хүрээгүй ялтан жилд 10, хөнгөвчилсөн нөхцөлд тус бүр 6 илгээмж гуйвуулга авах, мөн хөнгөн нөхцөлд тоон хязгаарлалтгүй удаан хугацааны уулзалт, хатуу нөхцөлд жилд 2 удаагийн уулзалт, тус бүр 6 илгээмж гуйвуулга авахыг зөвшөөрдөг. (улс, Эрүүгийн ял эдлүүлэх хууль)

Мөн хуулийн 154-р зүйлийн 2 хэсэгт ял эдлэх тогтоосон журмын ноцтой зөрчилд тооцох насанд хүрээгүй ялтны зөрчилд тооцох насанд хүрээгүй ялтны үйлдэл, эс үйлдэхүйг журамлаж өгсөн. Энэ нь:

1. Байгууллагыг тохижуулах, амьдрах нөхцөлийг сайжруулах ажил хийхээс хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр татгалзах,

2. Согтууруулах ундаа, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл хэрэглэх,

3. Байгууллагын захиргааны төлөөлөгчдийг заналхийлэх, доромжлох, тэдэнд захирагдахгүй байх болон ял эдлэх дэглэм зөрчих зорилгоор санаатайгаар биедээ ямар нэгэн гэмтэл учруулах,

4. Байгууллагын дотоод журамд тусгагдаагүй эд зүйлс, баримт бичиг, хэрэгсэл, бодис, хүнсний зүйлийг олж авах, дамжуулах, бэлтгэх, хадгалах,

5. Материаллаг болон бусад ашиг олох зорилгоор хөзөр, мөрийтэй бусад тоглоом тоглох,

6. Шүүхээс тогтоосон зайлшгүй болон албадлагын эмчилгээнээс зайлсхийх

7. Сексийн шинжтэй үйлдэл хийх,

8 Энэ хэсгийн 1-7 дэд хэсэгт заасан зөрчил гаргахад чиглэсэн ялтны бүлэглэлийг зохион байгуулах эсвэл түүнд оролцох,

в/ Насанд хүрээгүйчүүдийг хорих байдлын дунд түвшний байгууллагад 18 нас хүрсэн ялтныг тэдний саналыг авч 21 нас хүртэл нь байлгаж болох ба үүнийг байгууллагын даргын тодорхойлолтын үндсэн дээр шүүх шийдвэрлэнэ.

Босния Герцеговин: Босния Герцеговинд Чука сурган хүмүүжүүлэх төв ажилладаг. Түр байрлуулах төв нь ял хойшлогдсон хүүхдэд сургалт, хүмүүжлийн болон мэргэжил олгох сургалтыг зохион байгуулах, хүүхдийн харилцааны чадвар, эцэг, эхийн чадварыг нэмэгдүүлэх, биеийн тамирын арга хэмжээ, тоглоом, олон нийтийн клуб ажиллуулах, төрийн бус байгууллагатай хамтран ажилладаг.

Уг төвд хүүхэд 6 -12 сарын хугацаанд байх ба 7 хоногийн 4 өдрийг тухайн

төвд, 3 өдрийг эцэг, эх асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хараа хяналтад өнгөрүүлдэг. Орон нутгийн ял хойшлуулахыг хариуцах байгууллага нь өөрийн нэгжид дээрх төвийг байгуулдаг ба 2 ажилтан нь хөтөлбөрт хяналт тавьдаг. 8 сайн дурын ажилтан /сургуулийн оюутан/ ихэвчлэн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцдаг. Хүүхдийн шүүх нь Чукагийн амжилтыг харгалзаж, хугацааг богиносгосон ба хорихын оронд хүмүүжлийн дээрх байгууллагад шүүхийн шийдвэрийг явуулдаг болсон. (хүрээлэн, 2006)

ДҮГНЭЛТ

Бидний энд дурдсан судалгааны дүнгээс үзэхэд *“...ар гэрийн хараа хяналтгүй сул, санхүүгийн чадамжгүй байдал, гэр бүлийн зөрчил маргаан ихтэй, согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ өөрийгөө хянах чадваргүй болсон...”* зэрэг нөхцөл байдлууд нь өсвөр насны хоригдлуудын гэмт хэрэгт холбогдоход хамгийн их нөлөөлсөн хүчин зүйлс болж байна.

Түүнчлэн өсвөр насны хүмүүжигчдийн 60% орчим хувь нь өөртөө өгөх үнэлгээний түвшин доогуур гарсан байгаа нь өнөөгийн бидний амьдарч буй нийгэм дэх *“...Гэр бүлийн таагүй уур амьсгал, зөрчил маргаан, цаашилаад гэр бүл салалт, орчны нөлөөллийн асуудал нь хүүхдийн өөрийн үнэлгээ, өөртөө болон ирээдүйдээ итгэх итгэлийг бууруулах гол хүчин зүйл, гэмт хэрэг үйлдэх үндсэн шалтгаан...”* болж байна гэж дүгнэж болохоор байна.

Монгол Улсад өсвөр насны этгээдээс гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлж буй шалтгаан олон боловч хамгийн гол нь эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нарын хараа хяналт, анхаарал халамж муу байх, хүүхдийн нас, биеийн онцлогт тохируулан харьцахгүй байх, тэднийг үл хайхрах, тэднийг ойлгохыг хүсэхгүй байх, амьдралын наад захын хэрэгцээт зүйлсээр хангаж чадахгүй зэргээс үүдэн гэмт хэрэгт холбогдох явдал гарсаар байна. Шүүхийн журмаар гэрлэлт цуцлалт, тэтгэлэг гаргуулах хэрэг маргааны тоо буурахгүй байгаа бөгөөд үүний улмаас олон хүүхдүүдийн амьдралын баталгаа эрсдэлд орж байна.

Монгол Улс хэдийгээр насанд хүрээгүй буюу өсвөр насны этгээдэд оногдуулсан хорих ялыг эдлүүлж ирсэн эрх зүйн зохицуулалтын болон практик туршлага бий боловч шинээр батлагдсан Эрүүгийн болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд тусгагдсан Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага гэсэн шинэ нэр томьёонд хэрхэн ял эдлүүлэх талаар нэгдсэн ойлголт үгүй байна.

Олон Улсын жишгээс харахад Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага нь ял эдлүүлэх чиг үүргээсээ илүү сургалтын болон нийгэмшүүлэх үйл явцыг хэрэгжүүлдэг сургалтын орчин нөхцөлтэй байгууллага байна.

Гэвч манай улсад Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагын орчин нөхцөл нь хорих ангийн орчин нөхцөлтэй ижил, зарим талаараа тааруу байгаа нь учир дутагдалтай байна.

Хамгийн гол асуудал нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өсвөр насны этгээдэд ял эдлүүлэх явцад хэрхэн эрх эдэлж, үүрэг хүлээхийг тусгайлан зааж өгөх шаардлагатай талаарх зохицуулалт нь хэт ерөнхий, насанд хүрэгчидтэй адил зохицуулалттай байгааг анхаарч үзэх шаардлагатай гэж үзлээ. Иймд тухайн асуудлыг хуульд нарийвчлан оруулж өгөх шаардлагатай байна.

САНАЛ

Судлаачийн зүгээс өсвөр насны хүнд оногдуулсан хорих ял эдлүүлэх ажиллагааг хөгжин өөрчлөгдөж буй шинжлэх ухааны орчин үеийн чиг хандлагад нийцүүлж, хоригдлоос гадна бусад хүчин зүйл /ард иргэд, төр нийгмийн байгуулал, хүрээлэн буй орчны зэрэг/ бүхий л хүчин зүйлсийн аюул, эрсдэлийн түвшнийг ул суурьтай судалж, тогтоох, аюулгүй байдлын тухай онол, сургаалтай уялдуулан авч үзэж хөгжүүлэх.

Монгол Улсын Хууль зүй, Дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайд нарын хамтарсан “Жишиг норматив шинэчлэн батлах тухай” тушаалаар батлагдсан 15 хоригдол тутамд 1 хамгаалалтын ажилтан гэж заасныг мөрдүүлэх. Харуул хамгаалалтын хүч хангалтгүйгээс болж 1 алба хаагч амьдралын бүсэд үүрэг гүйцэтгэдэг үүнээс болж сонор сэрэмж алдах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх боломжгүй нөхцөл байдал үүсдэг.

Олон улсын байгууллагаас Сургалт- хүмүүжлийн тусгай байгууллага нь хорих байгууллага биш нэгдсэн хувцас, үс хусах гэх мэт хорих байгууллагад мөрдөгдөх зарим үйл ажиллагаа байх ёсгүй гэдэг боловч тус байгууллага хуульд зааснаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Өсвөр насны хоригдолд зориулсан тусгайлсан заалтыг нарийвчлан оруулж өгөх шаардлагатай байна.

Өсвөр насны хоригдолтой хамгийн ойр байж 24 цагаар үүрэг гүйцэтгэдэг харуул хамгаалалтын алба хаагчдыг чадваржуулан сургах, хүүхэдтэй ажиллах заах арга зүйн зохих мэргэжил, боловсрол эзэмшсэн багш мэргэжилтэй хүмүүсийг түлхүү авч алба хаагчдыг мэргэшүүлж ажиллуулах нь зүйтэй гэж үзэж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 1992 он.

Эрүүгийн хууль Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 2016 он.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Төрийн мэдээлэл. УБ., 2017 он.

Зөрчлийн тухай Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2017 он,

Хорих ангийн дотоод журам ХЗДХ сайдын тушаал. А/183. 2017 он.

А.Лхагва, М. (2024). Хорих ял эдлэгсдийг хүмүүжүүлэх-нийгэмшүүлэх ажлын зохион байгуулалт, эрх зүйн зохицуулалтын зарим асуудал. УБ.

Б.Ганчулуун. (2005). Английн Эрүүгийн эрх зүй. УБ.

Б.Тамир, (2021). Сургалт, хүмүүжлийн тусгай байгууллагын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн шинэтгэл” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл, 118.

Д.Дамдинцэрэн. (2021). Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилтийг хангахад ашиглагдах эмхтгэл. УБ.

Н.Гантулга. (2015). Хүний эрх ба хорих ял. УБ.

С.А., Х. (2019). Теория и практика ограничения свободы как вида наказания. Грозный.

С.Нарангэрэл. (2006). Эрх зүйн эх толь бичиг. УБ.

Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын тайлан. (2020-2025).

Э.Жамбалрагчаа, Э. (2021). Зорчих эрхийг хязгаарлах ялын техникийн хяналтыг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн шинэтгэл, 180.

---o0o---